Эрдэс баялгаас
эрдэм мэдлэг, ур чадвар,
үнэт зүйлс бүтээлцэнэ

Оюу Толгой

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

**"Оюу толгой"-н 2019 оны IV улирлын тойм мэдээ**

OTMongolia OTMongolia OyuTolgoi OTMongolia OTMongolia

## АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа нь бидний нэн тэргүүний зорилт. Аюултай гэж үзсэн ямар ч ажлыг ажилтан бүр шууд **зогсоох** эрхтэй.

2019 онд
34,209,153
Хүн/цаг

Зорилт
0.21-ээс бага байлгах
Гүйцэтгэл
0.16

2019 оны дөрөвдүгээр улирлын байдлаар гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 200,000 хүн/цаг тутамд 0.16 ногдож байгаа нь Рио Тинто группийн хэмжээнд аюулгүй ажиллагаар сайн хангадаг уурхайн нэг болж байна.

Ноцтой эрсдэлийн удирдлага
275,350
Магадлагаа

Амь хамгаалах зорилготой "Ноцтой эрсдэлийн удирдлага" хөтөлбөрийн хүрээнд 275,350 магадлагаа хийлээ.

## МОНГОЛ АЖИЛТНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үүрэг 90%

93%

Манай 13,800 орчим ажилтны 93.4 хувийг монгол иргэд бүрдүүлж байна. Нийт ажиллах хүчний 55.3 хувийг гүний уурхайн төслийн ажилтнууд юм. (2019 оны 12-р сарын 31-ний байдлаар)

## БОЛОВСРОЛ СУРГАЛТ

(Нийт хүн/цаг)

680,354

Нийт 680,354 хүн/цагийн сургалтад ажилтнуудаа хамруулан ажилчдынхаа ур чадварыг өсгөсөөр байна.

**БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР**
(Тэтгэлэг, бусад хөтөлбөрүүд)
2011 оноос хойш **2600** оюутан,

**ЗАЛУУСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**
2013 оноос хойш ахлах ангийн **1095** сурагч,

**"ГОВИЙН ОЮУ" САНГИЙН ТЭТГЭЛЭГ**
2015 оноос хойш Өмнөговийн **320** оюутан тус тус хамрагджээ

## ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ 2010-2019

(сая ам.доллар, жилээр)




2019 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 838 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 564 нь үндэсний компаниуд байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 76 хувийг зарцуулав. 2010-2019 онд үндэсний худалдан авалтад 3.1 тэрбум ам.доллар зарцуулсан.

## УСНЫ ХЭРЭГЛЭЭ

(Нэг тонн хүдэр боловсруулахад зарцуулсан усны хэмжээ, шоо метр, сараар)




1.2м³ 0.4м³

Нэг тонн хүдэр боловсруулахдаа 0.4м³ буюу дэлхийн ижил төрлийн уурхайнуудын ашиглалтын дундажаас даруй гурав дахин бага ус ашиглаж байна.

## УС АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

(2013-2019)

100
тэрбум төгрөг

## УС ДАХИН АШИГЛАЛТ

87%

2019 онд зорилтоо давуулан биелүүлж ус дахин ашиглалтын түвшинг дундажаар 87 хувьд хүргэв.




Өмнөговь аймгийн засаг дарга болон БОАЖ-ын сайдын захирамжийн дагуу ажлын хэсэг "Оюу Толгой"-н 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг "хангалттай хэрэгжүүлсэн" гэж дүгнэв.

# МАНАЙ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

“Оюу толгой”-н 2019 оны IV улирлын тойм мэдээ

OTMongolia OTMongolia OyuTolgoi OTMongolia OTMongolia

## ТАТВАР, ХУРААМЖ, БУСАД ТӨЛБӨР 2010-2019

(сая ам.доллар)




2010-2019 онд өсөн нэмэгдсэн дүнгээр

**2.6**

**ТЭРБУМ АМ.ДОЛЛАРЫГ**

татвар хураамж, бусад төлбөрт төлжээ.

2010 - 2019 оны хооронд 2.6 тэрбум ам.долларыг татвар, хураамж, Монголын компаниуд төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт төлсөн ба 2019 онд татвар, хураамж бусад төлбөрт 321 сая ам.доллар төлжээ.”

** “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.*

## ДОТООДОД ЗАРЦУУЛСАН НИЙТ МӨНГӨН ХӨРӨНГӨ 2010-2019

(тэрбум ам.доллар)

2010-2019 оны хооронд Монголын компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалин 10.3 тэрбум ам.доллар давлаа.




## ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

(сая ам.доллар)




**8.4**

сая ам.доллар

2019 ондоо тогтвортой хөгжилд чиглэсэн төслүүдэд үргэлжлүүлэн хөрөнгө оруулж, 8.4 сая ам.долларын санхүүжилт олгожээ.

## ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ХУДАЛДАН АВАЛТ 2010-2019

(сая ам.доллар)




2019 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 87 ханган нийлүүлэгч манайд бараа, үйлчилгээ нийлүүлэв. 2010-2019 онд Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалтад нийт 554 сая ам.доллар зарцуулжээ.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ ЗЭСИЙН ХЭМЖЭЭ

(мян.тонн)




2019 онд 125,000 – 155,000 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэх төлөвлөгөөндөө хүрч 146,346 тонн баяжмал дахь зэс үйлдвэрлэлээ.

## ҮЙЛДВЭРЛЭСЭН БАЯЖМАЛ ДАХЬ АЛТНЫ ХЭМЖЭЭ

(мян.унц)




Өнгөрсөн онд 241,840 унц баяжмал дахь алт үйлдвэрлэж 180,000 – 220,000 унц баяжмал дахь алт үйлдвэрлэх төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн.

## ГҮНИЙ УУРХАЙН ХӨНДЛӨН НЭВТРЭЛТ

(метр, сараар)




2019 онд гүний уурхайн нэвтрэлтийн ажил эрчимтэй үргэлжилж оны төгсгөлд хөндлөн малталтын гүйцэтгэл нийтдээ 14,874 метр, харин налуу амны малталтын ажил 3,490.5 метрийн ахицтай байлаа.

Оюу Толгой